

Засгийн газрын 2020 оны .... дугаар  
сарын ....-ны өдрийн ... дугаар  
тогтоолын хавсралт

## **МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛТАН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

Үндэсний статистикийн хорооноос ажиллах хүчний талаар 2018 онд хийсэн судалгааны тайлангаар Ажиллах хүч буюу 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам 1,358 сая байгаагаас 730.6 (53.8%) мянга нь эрэгтэй, 628.0 (46.5%) мянга нь эмэгтэйчүүд байна. Мөн эдийн засгийн идэвхтэй хүн амын 1,253 (92.2%) сая нь ажиллагчид, 105.6 (7.8%) мянга нь ажилгүй иргэд байна.

Ажиллагчдын 39.3 хувийг гэрээгээр ажиллагчид, 35 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 24.8 хувийг өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчид эзэлж байна. Хоршооллын гишүүд болон ажил олгогчид дөнгөж 0.2-0.6 хувийг эзэлж байна. Мөн өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчдын ихэнх нь буюу 61.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Ажил олгогч арван хүний ес нь, хувиараа хөдөлмөр эрхлэгч таван хүний гурав нь эрэгтэйчүүд байхад өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч таван хүний бараг дөрөв нь эмэгтэйчүүд байна.

Улсын хэмжээнд нийт ажилгүй иргэд 105.6 мянга байгаагийн 60.9 (57.7%) мянга нь эрэгтэйчүүд, 44.7 (42.3%) мянга нь эмэгтэйчүүд байна. Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 7.8 хувь, эрэгтэйчүүдийнх 8.3 хувь, эмэгтэйчүүдийнх 7.1 хувь байгаа бол байршлын хувьд хотод 9.4 хувь, хөдөөд харьцангуй бага буюу 5.2 хувьтай байна.

Ажилгүй иргэдийг насны бүтцээр нь харахад ихэвчлэн залуу хүмүүс, ялангуяа ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орогчид ажилгүйдэлд илүү өртөж байна. Нийт ажил эрхлээгүй хүн амын 56.1 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Нийт ажилгүй иргэдийн 77.7 (73.5%) мянга нь урт хугацаагаар (6-н сараас дээш), 65.3 (61.8%) мянга нь 12 түүнээс дээш сараар ажил хийх боломжтой байсан байна. Нийт ажилгүй иргэдийн 72.6 (68.8%) мянга нь тодорхой хэмжээний мэргэжил эзэмшсэн байна.

Ажилгүй иргэдийн ихэнх буюу 51.2 (48.5%) мянга нь ажил хайгаад олдохгүй байгаа, 13.6 (12.9%) мянга нь мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа, 10.0 (9.4%) мянга нь мэргэжил, дадлага туршлага байхгүйгээс ажил олдохгүй байна гэж хариулсан байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг хангасан мэргэжилтэн бэлтгэх нь чухал байгааг харуулж байна.

Хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хүрээнд хөнгөн, жижиг дунд үйлдвэрлэлийн хүний нөөцийн өнөөгийн байдал, нөхцөл байдлын шинжилгээ гаргахын тулд үйлдвэрлэгчид, ажил олгогчдоос авсан судалгаанаас харахад,

Хөнгөн үйлдвэрлэлийн салбарт нийт ажиллагсдыг /51200 хүн/ дэд салбараар нь авч үзвэл ноос ноолуур 44,3%, арьс шир 11,7%, барилгын материал үйлдвэрлэл 15,6%, мод 9,8%, хэвлэл 7,8%, оёдол, дахин боловсруулах 3,9%, сав баглаа боодлын салбарт 2 хувийг эзэлж байна.

ШУТИС -ийн ҮТС-д хөнгөн үйлдвэрийн элсэгч, төгсөгчдийн тоог сүүлийн 3 жилээр авч үзвэл, нийт элсэгч 394 оюутны 272 буюу дөнгөж **69 %** нь төгсөж мэргэжил эзэмшсэн байна.

Хүний нөөцийн эрэлт нэмэгдэж, суралцагсад, элсэгч төгсөгчийн тоо эрс багасаж байгаа энэ цаг үед эрэлтэд нийцсэн нийлүүлэлтийг хийхийн тулд холбогдох байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулах, эрх зүйн орчинг таатай болгох, хүний нөөцийн төлөвлөлт, бодлогын зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай байна.

Хөтөлбөрийн зорилгыг ажилгүй, орлогогүй иргэд тэр дундаа залуучуудыг богино хугацаанд үйлдвэрийн байранд цалинтай дадлага хийлгэх, онолын мэдлэгийг түргэвчилсэн байдлаар олгох замаар сертификат олгож ажлын байраар хангах, үйлдвэрүүдэд тулгамдаад байгаа ажиллах хүчний хомсдлыг багасгах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглүүлэхээр төлөвлөв.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.2.1-д “Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал”-ын зорилт 1-д “Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно”, зорилт 2-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна”, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.53.2-т “Мэргэжилтэй ажилтан хөтөлбөрийг боловсруулан батлуулах” гэж заасныг тус тус үндэслэн “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөр” (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг боловсрууллаа.

## **Хоёр. Хөтөлбөрийн зорилго**

2.1. Нэг талаас хөнгөн, хүнс, жижиг дунд үйлдвэрийн салбарт тулгамдаад буй ажиллах хүчний хомсдлыг богино хугацаанд шийдвэрлэх, нөгөө талаас ажилгүй, орлогогүй иргэдийг ажлын байран дахь дадлага давамгайлсан богино хугацааны сургалтад хамруулж, ажлын байраар хангаж ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

## **Гурав. Хөтөлбөрийн зорилт**

3.1. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

3.1.1. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, тогтвортой хадгалахад дэмжлэг үзүүлнэ;

3.1.2. Хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжил, ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн судалгааг үндэслэн ажил олгогчийн хэрэгцээнд нийцсэн

мэргэжилтэй ажилтанг богино хугацаанд үйлдвэрлэлийн дадлага давамгайлсан сургалтаар бэлтгэнэ;

3.1.3. Богино хугацаанд үйлдвэрлэлийн чиг баримжаа олгоход шаардагдах сурах бичиг, гарын авлага, видео хичээлийг бэлтгэх;

3.1.4. Мэргэжилтэй ажилтан түүний талаарх мэдээллийн нэгдсэн сантай болж, ажил олгогч, ажилтны талаарх мэдээлэл сургалт болон төгсөгчидтэй холбоотой мэдээллийн санг хөтлөх, бүртгэх, хадгалах чиглэлд техникийн болон програм хангамжийн нөхцөлийг бүрдүүлэх;

### **Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

4.1. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, тогтвортой хадгалахад дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. Барилга, зам, тээвэр, аялал жуулчлал, байгаль орчин, уул уурхай, боловсруулах үйлдвэр, эрчим хүч, худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах;

4.1.2. зохистой хөдөлмөрийг дэмжих замаар бүтээмжтэй, аюулгүй ажлын байрыг бий болгох, тогтвортой хадгалж байгаа ажил олгогчийг бодлогоор дэмжих, урамшуулах тогтолцоо бий болгох;

4.1.3. жижиг, дунд үйлдвэр, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах механизмыг боловсронгуй болгох;

4.2. Хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжил, ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн судалгааг үндэслэн ажил олгогчийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтанг богино хугацаанд үйлдвэрлэлийн дадлага давамгайлсан сургалтаар бэлтгэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчдын хэрэгцээ шаардлагыг үндэслэн элсэгчдийг бүртгэх, төгсөгчдийг ажлын байраар хангах нөхцөлийг ХНХЯ-тай хамтран бүрдүүлэх;

4.2.2. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдад хөдөлмөрийн харилцааны мэдлэг, ёс зүйг төлөвшүүлэн, мэргэжлийн чиг баримжаа олгох уулзалт, ярилцлага зохион байгуулах замаар богино хугацааны сургалтад хамруулан ажлын байраар хангах;

4.2.3. Зарим мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг үндэсний хэмжээний томоохон үйлдвэрлэл бүхий аж ахуйн нэгжийн дэргэд байгуулах, төрөлжүүлэх замаар мэргэжилтэй ажилтныг бэлтгэн нийлүүлэх;

4.2.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан, үйлдвэрлэлийн дадлага давамгайлсан, богино хугацааны сургалт зохион байгуулах механизм бий болгох;

4.2.5. Хөдөлмөр зуучлалын байгууллагуудыг дэмжих;

4.2.6. ХНХЯ-тай хамтран ажил хайж буй иргэдийг ажил олгогчтой холбох механизмыг сайжруулах;

4.2.7. Томоохон аж ахуйн нэгж, үйлдвэр нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн үйлдвэрт шаардлагатай ажилтанг үйлдвэрлэлийн дадлага хийлгэн чадавхижуулах, ажиллуулах;

4.3. Богино хугацаанд үйлдвэрлэлийн чиг баримжаа олгоход шаардагдах сурах бичиг, гарын авлага, видео хичээлийг бэлтгэх:

4.3.1. Орчин үеийн дэвшилтэт техник технологитой харьцах, эзэмшихэд шаардагдах гарын авлага, сурах бичгээр хангах;

4.3.2. ХАБЭА-н шаардлагыг ажлын байранд стандартын дагуу хангуулан ажиллахад шаардлагатай гарын авлагаар хангах, сургалтанд хамруулах;

4.3.1. Үйлдвэрлэлийн талаарх анхан шатны ойлголтыг залуучуудад сурталчлах, ойлгуулах видео хийчээл бэлтгэ, таниулах, сурталчлах;

4.4. Үйлдвэрүүд болон мэргэжилтэй ажилтаны талаарх мэдээллийн нэгдсэн сантай болж, ажил олгогч, ажилтны талаарх мэдээлэл сургалт болон төгсөгчидтэй холбоотой мэдээллийн санг хөтлөх, бүртгэх, хадгалах чиглэлд техникийн болон програм хангамжийн нөхцөлийг бүрдүүлэх:

4.4.1. Мэдээллийн нэгдсэн сангийн программыг ХНХЯ-тай хамтран боловсруулж мэргэжлийн байгууллагаар хийлгэх;

4.4.2. Мэдээллийн нэгдсэн сангийн программд богино хугацаанд сертификат авч ажлын байраар хангагдсан иргэдийн мэдээллийг оруулах;

#### **Тав. Хөтөлбөрийн хугацаа, шалгуур үзүүлэлт**

5.1. Хөтөлбөрийг 5 жилийн хугацаатай 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

5.1.1. Нэгдүгээр үе шат: 2020-2021 он

5.1.2. Хоёрдугаар үе шат: 2022-2024 он

5.2. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр тодорхойлно:

д/д		2020	2024
1	Хөтөлбөрийн хүрээнд шинээр бий болсон ажлын байр	-	
2	Хадгалагдсан ажлын байр	-	
3	Богино хугацаанд үйлдвэрлэлийн дадлага давамгайлсан сургалтаар бэлтгэндсэн ажиллах хүч	-	
4	Богино хугацаанд үйлдвэрлэлийн чиг баримжаа олгоход шаардагдах сурах бичиг, гарын авлага, видео хичээл	-	
5			
6			

#### **Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр**

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:

6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

6.1.2. олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламж;

6.1.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

6.1.4. Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө;

6.1.4.1. ЖДҮХС

6.1.4.2. ХААДС

6.1.4.3. ХЭДС

6.1.4.4. СХС

6.1.4.5. ТЭДС

6.1.4.6. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

6.1.5. хувийн хэвшил болон бусад эх үүсвэр.

### **Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт, шинжилгээ үнэлгээ**

7.1 Үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.

7.2. Үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

7.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

-----oOo-----